

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН АСУУДАЛ
ХАРИУЦСАН ОРЛОГУ

~~Ж.БАТБАЯСГАЛАН~~

**Д.ЛУВСАНШАРАВЫН НЭРЭМЖИТ ХҮҮХДИЙН НАЙРАЛ
ДУУНЫ ШИЛДЭГ ХАМТЛАГ ШАЛГАРУУЛАХ ХХVII
УДААГИЙН УРАЛДААНТ НААДМЫН УДИРДАМЖ**

Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулиудын хөгжмийн хичээлийн сургалтыг чанаржуулж, өсвөр үеийнхэнд уран сайхны боловсрол олгох, гоо зүйн хүмүүжлийг төлөвшүүлэх, хүүхэд бүрийн авьяасыг хөгжүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын ивээл дор уламжлал болон зохиогддог Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын жүжигчин Дагвын Лувсаншаравын нэрэмжит "Хүүхдийн найрал дууны шилдэг хамтлаг" шалгаруулах 27 дахь удаагийн уралдаант наадмыг Нийслэл Улаанбаатар хот үүсгэн байгуулагдсаны 380 жилийн ойд зориулан зохион байгуулж байна.

Найрал дууны уралдаант наадмын зохион байгуулалт:

Найрал дууны уралдаант наадмыг заавал дуулагдах дууны сургалтыг ЕБС-ийн хөгжмийн багш нарын дунд 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр зохион байгуулна.

Анхан шатны шалгаруулалт:

- Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар нутаг дэвсгэрийн Ерөнхий боловсролын сургуулиудыг уралдаанд бүрэн хамруулах ажлыг хариуцан зохион байгуулна.
- Анхан шатны шалгаруулалтыг 10 дугаар сарын 9, 10, 11-ний өдрүүдэд тусгай хуваарийн дагуу дүүрэгтээ зохион байгуулах бөгөөд Нийслэлийн Соёл, урлагийн газраас томилогдсон шүүгчдийн бүрэлдэхүүн дүүрэг тус бүрээс 3 шилдэг хамтлагийг шалгаруулна.
- Шүүгчдийн бүрэлдэхүүнээс нэг шүүгч, нэг дүүргийг хариуцан шалгарсан 3 хамтлагийг дүүргийн Засаг даргын тамгын газар болон тухайн сургууль, хөгжмийн багш нарт мэргэжил арга, зүйн зөвлөмж өгч төгсгөлийн шатны шалгаруулалтад оролцуулна.
- Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн соёлын асуудал хариуцсан мэргэжилтнүүд шалгарсан хамтлагуудын мэдүүлэг болон анхан шатны шалгаруулалтын талаарх илтгэх хуудсыг Нийслэлийн Соёл, урлагийн газарт 10 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ.

II шатны шалгаруулалт

Дүүрэг бүрээс эхний 3 байрт шалгарсан найрал дууны хамтлаг 2 дугаар шатны шалгаруулалтад оролцоно.

Нийслэлийн Соёл, урлагийн газар 2 дугаар шатны шалгаруулалтыг Монголын хүүхдийн ордонд 10 дугаар сарын 16-нд зохион байгуулна.

Хоёрдугаар шатны шалгаруулалтад амжилттай оролцсон сургуулиудын найрал дууны хамтлагуудын нэгдсэн тоглолтыг Нийслэл Улаанбаатар хот үүсгэн байгуулагдсаны 380 жилийн ойд зориулан 2019 оны 10 дугаар сарын 28-нд Нийслэлийн Соёлын төв өргөөнд зохион байгуулна.

Уралдаанд тавигдах шаардлага

Уралдаант наадамд оролцох хамтлагууд нийт 3 дуугаар оролцоно. Үүнд:

1. Заавал дуулах дуу / НСУГ -аас өгөх/
2. Акапелла буюу хөгжимгүй найрал дуу
3. Чөлөөт уран сэтгэмж бүхий найрал дуу /шоу хэлбэрийн/

Уралдаанд оролцогчдыг дараах үндсэн шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

1. Найрал дууны дуугаралт / хөг, үг хэллэг, хүчдэл, нийлэмж/
2. Хөгжмийн мэдрэмж утга санааг илэрхийлэх чадвар
3. Удирдаач багшийн үр чадвар
4. Бэлтгэл зохион байгуулалт /Тайзны соёл, хувцаслалт, хүүхдийн тоо 60-100 байх / зэрэг шалгуураар дүгнэж дараах байр эзлүүлэн шагнаж урамшуулна.

Уралдааны шагнал урамшуулал

Тэргүүн байр	1	Өргөмжлөл	5000.000 төгрөг
Дэд байр	1	Өргөмжлөл	4000.000 төгрөг
Гутгаар байр	1	Өргөмжлөл	3000.000 төгрөг
Тусгай байр	2	Өргөмжлөл	2000.000 төгрөг
Шилдэг удирдаач багш 1		Өргөмжлөл	1000.000 төгрөг

Жич: Найрал дууны хамтлаг, хөгжмийн багш нараа дэмжиж байнгын бэлтгэл зохион байгуулалттай байх боломж, нөхцөлөөр хангаж ажилласан нэг сургуулийн удирдлагыг шилдгээр шалгаруулж Өргөмжлөл мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

Ерөнхий зохион байгуулагч:

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

Хамтран зохион байгуулагч:

НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗАР
ДҮҮРГҮҮДИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
МОНГОЛЫН НАЙРАЛ ДУУНЫ УРАН БҮТЭЭЛЧДИЙН ХОЛБОО
МОНГОЛЫН ХҮҮХДИЙН ОРДОН
МОНГОЛЫН УРЛАГИЙН АЖИЛТНЫ ХОЛБОО

Холбоо барих утас: 321529, 99013783 /Нийслэлийн Соёл, урлагийн газар/